



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2025 оны 08 сарын 04 өдөр

Дугаар А/421

Номгон

「Соёл, урлагийн байгууллагуудыг мэргэжлийн  
хүний нөөцөөр хангах, чадавхжуулахад  
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.2, Төсвийн тухай хуулийн 14 зүйлийн 14.2.3, аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөний 6.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Соёл, урлагийн байгууллагуудыг мэргэжлийн хүний нөөцөөр хангах, чадавхжуулахад шаардагдах төсвийн зардлыг хавсралтаар баталсугай.

2.Дээрх үйл ажиллагаанд зарцуулагдах 19,984,000 (Арван есөн сая есөн зуун наян дөрвөн мянган) төгрөгийг аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

3.Соёл, урлагийн байгууллагуудыг мэргэжлийн хүний нөөцөөр хангах, чадавхжуулах ажлыг үр дүнтэй зохион байгуулахыг Нийгмийн бодлогын хэлтэс (В.Наранчимэг)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

642311085

Аймгийн Засаг даргын ...оньг ... дугаар сарын  
 04 -ний өдрийн ... дүгээр захирамжийн  
 хавсралт



СОЁЛ, УРЛАГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫГ МЭРГЭЖЛИЙН  
 ХҮНИЙ НӨӨЦӨӨР ХАНГАХ, ЧАДАВХЖУУЛАХ АЖЛЫН  
 ЗАРДЛЫН ТООЦОО

№	Материал, бараа бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	Нэгжийн үнэ	Нийт үнийн дүн /сая/
1	Соёлын төв, мэргэжлийн урлагийн байгууллагын хүнийг нөөцийг нэмэгдүүлэх, дутагдалтай орон тоог тодорхой хувиар бууруулах.	Хүн	9,984,000	9,980,000
2	Тээвэр, шатахууны хөлс (Баянхонгор аймаг-Улаанбаатар хот)	Хүн	40*100,000	4,000,000
3	Сургалтын материал, хэрэглэгдэхүүний хэвлэлийн зардал	ш	100*30,000	3,000,000
4	Даавуун хэвлэл, стэндний зардал	-		2,200,000
6	Сургалтын цайны зардал	Хүн/мян/удаа	40*5,000*4	800,000
7	<b>Нийт</b>			<b>19,984,000</b>

оОо